



Улсын Статистикийн Хэлтэс



# ДОРНОД АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2014 оны 5 дугаар сарын байдлаар)

Ч᠋ᠢ ᠡ᠋ᠠᠠᠡᠨᠠᠢ ᠣᠢ ᠋᠋



ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠦᠰ

## Агуулга

1. Эхний хагас жилийн мал тооллогын түүвэр судалгаа, Хүн амын мэдээллийн сангийн талаар
2. “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2013”-ын үр дүнгээс
3. Дорнод аймгийн нийгэм, эдийн засгийн байдал




ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠵᠠᠰᠤᠭᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ, ᠳᠡᠯᠬᠢᠶᠢᠨ ᠪᠠᠨᠭᠨᠢ ᠣᠯᠠᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠰᠴᠣᠢᠨᠠᠵᠢ ᠬᠣᠷᠣᠨᠳ 2005 ᠣᠨᠢ 6 ᠰᠠᠷᠢᠨ 17-ᠨᠢ ᠦᠳᠦᠷ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠰᠠᠨ “ᠮᠠᠯᠢᠨ ᠢᠨᠳᠡᠭᠰᠢᠵᠤᠯᠤᠰᠢᠨ ᠳᠠᠠᠲᠭᠠᠯ” ᠲᠦᠰᠤᠯᠢᠶᠢᠨ ᠬᠥᠭᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠵᠡᠭᠡᠯᠢᠶᠢᠨ ᠭᠡᠷᠡᠭᠡᠨᠢᠶ 4 ᠳᠦᠭᠡᠷ ᠬᠠᠪᠰᠢᠷᠠᠯᠲᠢᠨ 4-ᠲ ᠵᠠᠠᠰᠢᠨᠢ ᠳᠠᠭᠤᠦ ᠤᠨᠳᠡᠰᠢᠨᠢ ᠰᠠᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠣᠷᠣᠭ ᠡᠬᠢᠨᠢ ᠬᠠᠭᠠᠰ ᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠮᠠᠯ ᠲᠣᠯᠯᠣᠭᠢᠨ ᠲᠦᠭᠦᠷ ᠰᠤᠳᠠᠯᠭᠠᠭ ᠵᠣᠬᠢᠣᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠵ ᠪᠠᠶᠢᠨᠠ. ᠮᠠᠨᠠᠶ ᠠᠶᠢᠮᠠᠭᠲ ᠡᠨᠡ ᠣᠨᠢ ᠬᠠᠭᠠᠰ ᠵᠢᠯᠢᠶᠢᠨ ᠮᠠᠯ ᠲᠣᠯᠯᠣᠭᠢᠨ ᠲᠦᠭᠦᠷ ᠰᠤᠳᠠᠯᠭᠠᠭ 6 ᠳᠤᠭᠠᠷ ᠰᠠᠷᠢᠨ 5-ᠨᠠᠠᠰ 12-ᠨᠢ ᠦᠳᠢᠷᠦᠭᠦᠳᠦᠳ ᠠᠶᠢᠮᠢᠭᠢᠨ ᠬᠡᠮᠵᠡᠭᠡᠨᠳ 2007 ᠦᠷᠬᠢᠶᠭ ᠬᠠᠮᠢᠷᠤᠯᠵ ᠪᠠᠶᠢᠨᠠ.

## НЭГ. Эхний хагас жилийн мал тооллогын түүвэр судалгаа, Хүн амын мэдээллийн сангийн талаар


- ✓ Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны олон улсын ассоциаци хооронд 2005 оны 6 сарын 17-ны өдөр байгуулсан “Малын индексжүүлсэн даатгал” төслийн Хөгжлийн зээлийн гэрээний 4 дүгээр хавсралтын 4-т заасны дагуу Үндэсний статистикийн хороо эхний хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг зохион байгуулж байна. Манай аймагт энэ оны хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааг 6 дугаар сарын 5-наас 12-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд 2007 өрхийг хамруулж байна.
- ✓ Аймгийн Засаг даргын 2014 оны А/42 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллах үүднээс хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтрийн програмыг онлайн горимд шилжүүлэх ажлын хүрээнд аймгийн 14 суманд 6 дугаар сарын 13-25-ны өдрүүдэд онлайн програмын сургалтыг зохион байгуулана. Энэхүү сургалтын гол зорилго нь хүн амын нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, хүн амтай холбоотой тоон мэдээллийг онлайн түвшинд гаргах юм.

## ГУРАВ. ДОРНОД АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ: ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд нийт 800 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 800 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 9 буюу 1.7%-иар, хүүхдийн тоо 14 буюу 1.7%-иар тус тус буурчээ.



Хүн амын нас баралт 204 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 хүн ам тутамд 2.72 ноогдож, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 20 буюу 10.9%-иар өссөн байна. Нас баралтын шалтгаанд хорт хавдрын нас баралт 52 тохиолдол буюу 25.5%, осол гэмтлийн нас баралт 39 тохиолдол буюу 19.1%-ийг тус тус эзэлж байна.





## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг

2014 оны 5 дугаар сарын байдлаар 228 гэмт хэрэг гарч үүний улмаас 8 хүн нас барж, 449.0 сая төгрөгийн хохирол учирчээ. Нийт гарсан гэмт хэргийн 52 хэргийг 52 хүн согтуугаар үйлдсэн байна. Учирсан хохирлын хэмжээг 2013 оны мөн үетэй харьцуулахад 51.1 сая төгрөгөөр өссөн байна.

Дорнод аймгийн хэмжээнд гарсан нийт гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 134 хэргээр буюу 58.8 хувиар буурсан үзүүлэлтэй байна.


ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠯᠡᠭᠡᠨ  
ᠤᠨᠳᠡᠰᠦᠨᠢ  
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠢ  
ᠬᠡᠯᠲᠡᠰ




## ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр

Ажлын шинэ байранд 527 иргэн ажилд орсон байна. Эдгээр хүмүүсийг мэргэжлээр нь авч үзвэл худалдаа үйлчилгээний мэргэжлийн ажилд 68, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэжлийн ажилд 165, үйлдвэрлэл, уул уурхайн салбарт 176, боловсруулах салбарт 79, бусад салбарт 39 хүн шинээр ажилд орсон байна

Шинээр ажлын байранд орсон иргэд насны бүлгээр



### Бүртгэлтэй ажилгүй иргэдийн мэдээ



Аймгийн хэмжээнд нийт 2035 бүртгэлтэй ажилгүйчүүд байгаа ба үүний 50.1 хувийг бүрэн дунд боловсролтой хүмүүс эзэлж байна.

ᠬᠤᠨ ᠠᠮ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠤᠵᠦᠭᠦᠯᠡᠯᠲᠤ - Хөдөлмөр

## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, улсын хэмжээнд 2014 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 1.5 хувь, оны эхнээс 6.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 13.7 хувиар өслөө. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2014 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас бүх аймагт 0.2-5.5 хувиар өсчээ. Сэлэнгэ (5.5%) аймаг хамгийн их өсөлттэй байна. Манай хувьд өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна.

6 сарын 11-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг судлахад хонины мах 7000-7500 төгрөг, үхрийн мах 8500-9500 төгрөг, элсэн чихэр 1700, цагаан будаа 2000, шингэн сүү 800 төгрөг, Нэг литр А-80 бензин 1630 төгрөг, А-92 бензин 1880 төгрөг, дизель түлш 1930 төгрөгийн үнэтэй байна.



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв, тээвэр, холбоо



**Төсөв, санхүү**: Аймгийн төсвийн орлого 23192.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 23983.8 сая төгрөг болж, 47.0 хувиар давж биелэлээ.



Аймгийн төсвийн нийт зарлага 25087.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 19734.5 сая төгрөг болж төлөвлөгдсөн зардлын 78.7 хувийг санхүүжүүлсэн.

### Банк

Арилжааны банкнуудын жилийн хадгаламжын үлдэгдэл 41.9 тэрбум төгрөг, зээлийн өрийн үлдэгдэл 126.9 тэрбум төгрөг.  
Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 379.6 сая төгрөг.




# Ам.долларын ханшийн мэдээлэл



МОНГОЛЫН УЛСЫН СТАТИСТИКИЙН АГЫН ГЭРЭЛ

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

## Төллөлтийн хувь



Одоогийн байдлаар мал төллөлт 435972 төл авснаас 99.5 хувь нь бойжиж байгаа ба төллөлтийн хувь 78.9 байна. 5 сарын байдлаар том малын зүй бусын хорогдол 7150 толгойд хүрснээс тэмээ 54, адуу 460, үхэр 671, хонь 3366, ямаа 2599 толгойд хүрлээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 35454 толгойгоор буурчээ. Нийт хорогдлын 28.8 хувийг Баяндун сумын хорогдол эзэлж байна.




ᠮᠠᠬᠤᠷ᠎ᠠ ᠡᠳᠢᠶ᠋ᠢᠨ ᠵᠠᠰᠭᠢᠨ ᠤᠰᠤᠭᠤᠯᠡᠯᠲᠤ

## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд хаврын тариалалтын мэдээгээр улаан буудай 8150 га, арвай 615 га, овъёос 30 га, рапс 18200 га, эмийн ургамал 500 га, төмс 143.5 га, хүнсний ногоо 39.6 га-д тус тус тариалаад байна.

Улаан буудайн зах зээлд борлуулах үнэ хямд байгаатай холбоотой улаан буудай тариалж байсан зарим газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгжүүд тосны ургамал болох рапсыг сүүлийн 2 жилд их хэмжээгээр тариалж байгаа нь тариалбал зохих хэмжээнээс их байна.



Улаан буудайн зах зээлд борлуулах үнэ хямд байгаатай холбоотой улаан буудай тариалж байсан зарим газар тариалан эрхэлдэг аж ахуй нэгжүүд тосны ургамал болох рапсыг сүүлийн 2 жилд их хэмжээгээр тариалж байгаа нь тариалбал зохих хэмжээнээс их байна.


## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн газрууд 13572.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 13664.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлууллаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 21.7% буюу 2416.4 сая.төг-өөр өсч, борлуулалт 31.4% буюу 3258.8 сая.төг-өөр өссөн байна.

Адуунчулуун ХК 210.8 мянган тонн нүүрс олборлосон бол ДБЭХС ХК 49765.0 мян.квт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 120748.0 мян.г.калори дулаан хэрэглэгчдэд түгээжээ. Дорнод Гурил ХХК 2929.5 тн гурил, 930.1 тн хивэг, 355.5 тонн талх үйлдвэрлэлээ.



Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн,  
борлуулалт. Сая төгрөгөөр





[www.dornod.nso.mn](http://www.dornod.nso.mn)

[www.nso.mn](http://www.nso.mn)

Phone-70582879

70584240

[dstatistic@yahoo.com](mailto:dstatistic@yahoo.com)

[dornod@nso.mn](mailto:dornod@nso.mn)

